

**ҮНДЭСНИЙ БӨХИЙН ӨСВӨРИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН**

2019.10.15

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Биеийн тамир, спортын газар, аймгийн Үндэсний бөхийн холбоо, Монголын Үндэсний бөхийн холбоотой хамтран зохион байгуулсан Үндэсний бөхийн 2019 оны өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд 21 аймаг, 9 дүүрэгийн нийт -90 өсвөр үеийн бөх, 30 багш дасгалжуулагч нар оролцлоо. Үндэсний бөхийн өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Дундговь аймгийн Мандалговь хотноо хоёр өдрийн турш үргэлжилж багийн дүнгээр Ховд аймаг тэргүүллээ. Мөн багийн дүнгээр Хоёрдугаар байрт Хан-Уул дүүрэг, Гуравдугаар байрт Увс аймаг тус тус шалгарчээ. Тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагаанд Дундговь аймгийн засаг дарга О.Бат-Эрдэнэ, Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга М.Наранбадрах, аймгийн Үндэсний бөхийн холбооны тэргүүн О.Ганбат, Монгол улсын үндэсний бөхийн холбооны тэргүүлэгчид оролцлоо.

Улсын аварга шалгаруулах тэмцээн нь 56 дахь жилдээ болж буй бөгөөд 16, 17, 18 гэсэн гурван насны ангиллаар 90 бөх хүч сорин өрсөлдсөн юм.

Үүнээс:

16 насны ангилалд

- 1-р байр: Ц.Түвшэндорж /Сэлэнгэ/
- 2-р байр: Н.Батбөх /БЗД/
- 3-р байр: Д.Бямба-Эрдэнэ /Сүхбаатар/
- 4-р байр: Н.Амаржаргал /Баян-Өлгий/
- 5-р байр: Сумъяабазар /Ховд/
- 6-р байр: Н.Нямдаваа /СХД/
- 7-р байр: С.Занданхүү /ХУД/
- 8-р байр: Л.Чинбат /Увс аймаг/
- 9-р байр: Т.Даваадорж /Завхан/
- 10-р байр: Э.Анхбаяр /Багануур/

17 насны ангилалд

- 1-р байр: Г.Баянмөнх /Увс/
- 2-р байр: Г.Батзориг /Ховд/
- 3-р байр: Ш.Энхбаясгалан /Чингэлтэй/
- 4-р байр: Б.Орших /Архангай/
- 5-р байр: Ц.Мөнхбаяр /Булган/
- 6-р байр: Б.Дашдаваа /Говь-Алтай/
- 7-р байр: Э.Уугангэрэл /Хэнтий/
- 8-р байр: Б.Шатар /Хан-Уул/
- 9-р байр: Д.Саранцогт /Өвөрхангай/
- 10-р байр: С.Дархансүх /Дархан-Уул/

18 насны ангилалд:

- 1-р байр: Э.Батмагнай / Баянхонгор/
- 2-р байр: Б. Ганхулэг /Хан-Уул/
- 3-р байр: Б.Цогт /Багануур/
- 4-р байр: Б.Шаравдорж /Архангай/
- 5-р байр: Ө.Бумба-Очир /Говьсүмбэр/

6-р байр: Н.Баярбаатар /Төв/
 7-р байр: М.Од-Эрдэнэ /Хэнтий/
 8-р байр: М.Баяржавхлан /Ховд/
 9-р байр: Б.Бум-Эрдэнэ / Сүхбаатар/
 10-р байр: Б.Мөнхбаяр / Дархан –Уул/

Уран гараа дэвээ

16 нас: З.Эрхэмбаяр /Чингэлтэй/
 17 нас: Ц.Мөнхбаяр / Булган/
 18 нас: Т.Мөнх-Ёндөн / Багахангай/

Уран барилдаанч бөх

16 нас: Л.Чинбаяр / Увс/
 17 нас: Э.Уугангэрэл / Хэнтий/
 18 нас: Н.Баярбаатар /Төв/

БАГИЙН ДҮНГЭЭР:

1-р байр: Аймгийн заан Нямдэлэг дасгалжуулагчтай Ховд аймаг
 2-р байр: Ч.Нямдорж дасгалжуулагчтай Хан-Уул дүүрэг
 3-р байр: Аймгийн заан Т.Хайдав дасгалжуулагчтай Увс аймаг
 4-р байр: Сүхбаатар дасгалжуулагчтай Чингэлтэй дүүрэг
 5-р байр: Аймгийн арслан Л.Жамбал дасгалжуулагчтай Архангай аймаг
 6-р байр: Аймгийн начин Э.Бат-Эрдэнэ дасгалжуулагчтай Сэлэнгэ аймаг тус тус шалгарлаа.

Түүнчлэн Уран барилдаанч болон Уран гараа дэвээтэй бөхчүүдийг шалгаруулан, шагнал гардууллаа.

Тэмцээний хаалтын барилдаанд:

Аймгийн арслан Л.Жамбал түрүүлж. / Архангай аймаг /
 Үзүүр: Аймгийн начин С.Лундаа /Дундговь аймаг/
 Их шөвөг: Аймгийн начин Э.Батмагнай /Баянхонгор аймаг/
 Их шөвөг: Аймгийн начин Ш.Цэрэнбат /Дундговь аймаг / тус тус шалгарлаа.

9

“БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ-ГЯЛГАР УУТНААС ТАТГАЛЗЬЯ” ЯВГАН АЯЛЛЫН ТАЙЛАН

2019.05.14 нд

Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, хамтран хэрэгжүүлэгч Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” зорилгоор зохион байгуулж буй “БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ” аяны хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар хамтран “БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ-ГЯЛГАР УУТНААС ТАТГАЛЗЬЯ” явган аяллыг 2019 оны 05 дугаар сарын 14-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд 25 байгууллагын 200 гаруй албан хаагчид оролцон, Чагдаржавын талбайгаас эхлэн “Хөрхийн хад” хүртэл маршрутаар гялгар уут түүж, байгалиа хамгаалах үйлсэд нэгдлээ.

Аяллын туршид идэвх оролцоогоороо манлайлан оролцсон Сайнцагаан сумын Ахмадын хороог “БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА”-аар өргөмжлөв.

Мөн багуудын дунд хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион байгуулсан ба

1-р байр –Онцгой байдлын газар

2-р байр-Цагдаагийн газар

3-р байр – Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв тус тус шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа. Буухиа тэмцээнийг Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн С.Цолмон, дасгалжуулагч Д.Болор-Эрдэнэ, дасгалжуулагч Ц.Отгончулуун нар шүүч спортын арга хэмжээг зохион байгууллаа.

Явган аялалд идэвхтэй оролцсон нийт байгууллага, хамт олонд талархал илэрхийлье.


Тайлан бичсэн мэргэжилтэн

С.Цолмон

- ◆ Аялагчид илчлэг сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан бэлэн хүнс, ус, ундаа бэлтгэн аялалын үүргэвчтэй байна.
- ◆ Хог түүх шуудай, бээлий, савар гэх мэт шаардлагатай зүйлсийг хангах

Зөвлөмж, анхаарах асуудлууд:

- ◆ Нээлтийн арга хэмжээнд багийн зохион байгуулалттай оролцох
- ◆ Цаг баримтлах
- ◆ Аялалын явцад тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.
- ◆ Аялах явцдаа нэмж хог хаяхгүй байж, шуудайнд цуглуулах
- ◆ Ил задгай гал түлэх, тамхи, шүдэнз хаяхгүй байх
- ◆ Аялалын маршрутын зураг:






Утас: 99598380 - БТСГ

88138901- БОАЖГ

88258807- ЭМГ

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД



“БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ-ГЯЛГАР УУТНААС ТАТГАЛЗЪЯ” ЯВГАН АЯЛАЛЫН УДИРДАМЖ

Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, хамтран хэрэгжүүлэгч Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” зорилгоор зохион байгуулж буй “БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ” аяны хүрээнд зохион байгуулна.

Зорилго: Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, гялгар уутны хор уршгийг таниулах, байнгын хэрэглээнээс бүр мөсөн татгалзах сэтгэлгээг иргэд, олон нийтэд бий болгох, иргэдийн хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх, гялгар уутнаас үүдэлтэй халдварт бус өвчлөлөөс сэргийлэхэд зорилго оршино.

Хугацаа: 2019 оны 05 сарын 14-ны өдрийн Мягмар гаригт 09⁰⁰-14⁰⁰ хүртэл.

Маршрут: Чагдаржавын талбайгаас эхлэн Хөрхийн хад хүртэл 4 км үргэлжилнэ. (Хогийн цэгийн зүүн урд талын дэрсний хавьд гялгар уут түүх)

Хамрах хүрээ: Төрийн бүх албан байгууллагууд, Хувийн аж ахуйн нэгжийн төлөөлөл З-аас доошгүй хүн.

Явган аялалын үеэр зохион байгуулагдах арга хэмжээ:

- ✚ Нээлт – Аймгийн ИТХ, БОАЖГ, БТСГ, ЭМГ
- ✚ Аймгийн төвийн бохирдол бүхий зүүн урд хэсэгт гялгар уут түүх ба аялалын явцад хамгийн их гялгар уут түүсэн байгууллагыг шалгаруулж, урамшуулах – БОАЖГ
- ✚ Буухиа тэмцээн – БТСпортын газар, ЭМГазар хариуцна. (Эрэгтэй-5, эмэгтэй-5 хүний бүрэлдэхүүнтэй оролцоно.)
- ✚ Хаалт- БОАЖГ, БТСГ, ЭМГ
- ✚ Түүсэн гялгар уут хогийг хогийн цэгт хүргэх – Сайнцагаан сумын ЗДТГ

Зохион байгуулалт:

- ✚ Хамгийн идэвхтэй оролцсон ААН, байгууллагыг шалгаруулж, шагнаж урамшуулна. (Жич: ирц, оролцооны байдал, гялгар уут түүсэн хэмжээгээр дүгнэх)
- ✚ Байгууллага бүр албан хаагчийн ирцийг бүрэн хамруулж, 1-2 ахлагчтай байна.

Зургаа. Хувийн бэлтгэл

- ✚ Аялагчид тухайн өдрийн цаг агаарт тохирсон спорт, аялалын хувцас, хэрэглэлтэй байна.